

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/233/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны яам
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЗОРИГ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.24 № 01/136
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,685,800.00	4,971,296.84
33	АВЛАГА	0.00	3,043,700.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	3,043,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,685,800.00	1,333,100.00
354	Хангамжийн материал	2,685,800.00	1,333,100.00
35410	Бичиг хэргийн материал	330,000.00	260,000.00
35420	Аж ахуйн материал	604,500.00	430,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	170,000.00	20,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,581,300.00	623,100.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	594,496.84
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	0.00	594,496.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,008,031,004.12	1,102,764,867.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,008,031,004.12	1,102,764,867.70
392	Биет хөрөнгө	972,121,004.12	1,066,334,867.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	908,579,919.15	908,579,919.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,831,521.28	-41,747,281.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,600,000.00	107,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,766,666.63	-38,699,999.99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,465,549.20	132,604,747.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,534,107.67	-35,092,125.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,150,429.34	59,458,383.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,754,475.99	-36,580,653.49
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,400,000.00	5,400,000.00
39217	Ном	4,811,878.00	4,811,878.00
393	Биет бус хөрөнгө	35,910,000.00	36,430,000.04
39301	Програм хангамж	6,419,500.00	6,267,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,759,500.00	-4,086,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	34,250,000.00	34,250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,010,716,804.12	1,107,736,164.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,525,391.81	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,525,391.81	
413	Өглөг	4,525,391.81	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,400,611.79	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	124,780.02	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,006,191,412.31	1,107,736,164.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,006,191,412.31	1,107,736,164.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	185,365,274.48	185,365,274.48
51101	Өмч: - төрийн	185,365,274.48	185,365,274.48
512	Хуримтлагдсан үр дүн	729,602,255.64	833,379,431.87
51210	Өмнөх үеийн үр дүн	752,124,117.54	731,834,679.64
51220	Тайлант үеийн үр дүн	-22,521,861.90	101,544,752.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	91,223,882.19	88,991,458.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,010,716,804.12	1,107,736,164.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,462,362,809.15	3,926,991,398.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,159,069.15	338,937,836.75
120	Нийтлэг татварын бус орлого	169,159,069.15	338,937,836.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	169,159,069.15	338,937,836.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	169,159,069.15	338,937,836.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,293,203,740.00	3,588,053,561.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,233,022,200.00	3,223,178,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,233,022,200.00	3,223,178,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,181,540.00	364,874,961.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	6,086,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,300,000.00	18,018,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,301,540.00	337,270,561.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,580,000.00	3,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,484,884,671.05	3,825,446,646.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,484,884,671.05	3,825,446,646.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625,547,097.49	975,857,890.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,279,811.77	279,990,889.30
210101	Үндсэн цалин	220,153,155.00	199,522,568.12
210102	Нэмэгдэл	68,126,656.77	55,873,921.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	12,729,646.02
210104	Урамшуулал	0.00	11,864,754.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,082,572.14	36,634,487.72
210201	Тэтгэврийн даатгал	24,646,584.62	25,365,820.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,899,529.15	2,820,908.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,312,958.55	2,253,366.96
210204	Ажилгүйдлийн даатгал	565,772.80	560,970.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,657,727.02	5,633,421.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,704,889.34	36,956,834.37
210301	Гэрэл, цахилгаан	1,529,497.34	1,584,672.45
210302	Түлш, халаалт	33,804,322.00	33,804,323.24
210303	Цэвэр, бохир ус	2,371,070.00	1,567,838.68
2104	Хангамж, бараа материалын зардал	140,649,937.15	266,087,754.45
210401	Бичиг хэрэг	1,118,600.00	16,529,641.82
210402	Тээвэр, шатахуун	5,529,600.00	3,770,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,300.00	974,039.60
210404	Ном, хэвлэл	242,200.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,244,000.00	26,826,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	954,520.00	2,898,070.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	130,312,717.15	214,988,413.03
2105	Нормативт зардал	0.00	3,633,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	3,633,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,812,900.00	165,130.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	4,312,900.00	165,130.00
2107	Томилолт, зочны зардал	6,562,900.00	54,000.00
210702	Дотоод албан томилолт	6,562,900.00	54,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,470,461.00	279,403,431.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	27,470,461.00	279,403,431.00

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,983,626.09	72,931,763.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	260,000.00	1,328,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,436,304.00	21,113,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,287,322.09	50,490,063.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,859,337,573.56	2,849,588,756.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,842,666,981.00	2,780,407,693.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,495,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,471,545,781.00	1,397,860,603.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,358,916,200.00	1,363,719,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,710,000.00	18,828,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,670,592.56	69,181,062.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,670,592.56	69,181,062.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22,521,861.90	101,544,752.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22,521,861.90	101,544,752.23

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	185,365,274.48	93,793,291.19	749,554,708.54	1,028,713,274.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,569,409.00	2,569,409.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,365,274.48	93,793,291.19	752,124,117.54	1,031,282,683.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-2,569,409.00	0.00	-2,569,409.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,521,861.90	-22,521,861.90
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	185,365,274.48	91,223,882.19	729,602,255.64	1,006,191,412.31
D01	2021 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	185,365,274.48	91,223,882.19	729,602,255.64	1,006,191,412.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,232,424.00	2,232,424.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,365,274.48	91,223,882.19	731,834,679.64	1,008,423,836.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-2,232,424.00	0.00	-2,232,424.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	101,544,752.23	101,544,752.23
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	833,379,431.87	1,107,736,164.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,307,163,740.00	3,588,053,561.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,307,163,740.00	3,588,053,561.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,233,022,200.00	3,223,178,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,233,022,200.00	3,223,178,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,141,540.00	364,874,961.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	6,086,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,300,000.00	18,018,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,301,540.00	337,270,561.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,540,000.00	3,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,307,163,740.00	3,564,353,561.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,307,163,740.00	3,564,353,561.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,826,166.44	711,721,105.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275,737,337.56	284,391,500.81
210101	Үндсэн цалин	205,308,879.56	205,488,712.79
210102	Нэмэгдэл	51,851,802.00	54,566,803.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,762,053.00	12,471,231.02
210104	Урамшуулал	12,814,603.00	11,864,754.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,528,434.56	36,634,488.00
210201	Тэтгэврийн даатгал	26,643,334.96	25,365,816.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,721,477.46	2,820,908.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,177,660.17	2,253,367.06
210204	Ажилгүйдлийн даатгал	544,318.29	560,970.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,441,643.68	5,633,424.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,580,109.32	37,081,614.39
210301	Гэрэл, цахилгаан	1,404,717.32	1,709,452.47
210302	Түлш, халаалт	33,804,322.00	33,804,323.24
210303	Цэвэр, бохир ус	2,371,070.00	1,567,838.68
2104	Хангамж, бараа материалын зардал	10,637,220.00	49,023,841.42
210401	Бичиг хэрэг	1,118,600.00	16,459,641.82
210402	Тээвэр, шатахуун	5,529,600.00	3,770,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,300.00	974,039.60
210404	Ном, хэвлэл	242,200.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,244,000.00	26,826,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,254,520.00	892,570.00
2105	Нормативт зардал	0.00	3,633,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	3,633,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,917,400.00	165,130.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	4,417,400.00	165,130.00
2107	Томилолт, зочны зардал	6,562,900.00	54,000.00
210702	Дотоод албан томилолт	6,562,900.00	54,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,166,461.00	279,403,431.00

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,166,461.00	279,403,431.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,696,304.00	21,333,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	260,000.00	220,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,436,304.00	21,113,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,859,337,573.56	2,852,632,456.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,842,666,981.00	2,780,407,693.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,495,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,471,545,781.00	1,397,860,603.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,358,916,200.00	1,363,719,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,710,000.00	18,828,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,670,592.56	72,224,762.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,670,592.56	72,224,762.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	23,700,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	23,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	23,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	23,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	23,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-23,700,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,223,178,600.00	3,153,997,537.20	69,181,062.80	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,223,178,600.00	3,153,997,537.20	69,181,062.80	97.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,950,400.00	392,089,843.80	1,860,556.20	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,410,200.00	284,391,500.81	18,699.19	100.0
210101	Үндсэн цалин	218,784,300.00	205,488,712.79	13,295,587.21	93.9
210102	Нэмэгдэл	51,958,200.00	54,566,803.00	-2,608,603.00	105.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,976,000.00	12,471,231.02	-3,495,231.02	138.9
210104	Урамшуулал	4,691,700.00	11,864,754.00	-7,173,054.00	252.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,395,400.00	36,634,488.00	1,760,912.00	95.4
210201	Тэтгэврийн даатгал	28,255,000.00	25,365,816.82	2,889,183.18	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,535,100.00	2,820,908.89	-285,808.89	111.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,028,100.00	2,253,367.06	-225,267.06	111.1
210204	Ажилгүйдлийн даатгал	507,000.00	560,970.93	-53,970.93	110.6
210205	Эрүүл мэндийн даатгал	5,070,200.00	5,633,424.30	-563,224.30	111.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,103,200.00	37,081,614.39	21,585.61	99.9
210301	Гэрэл, цахилгаан	1,709,800.00	1,709,452.47	347.53	100.0
210302	Түлш, халаалт	33,808,400.00	33,804,323.24	4,076.76	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,585,000.00	1,567,838.68	17,161.32	98.9
2104	Хангамж, бараа материалын зардал	7,185,800.00	7,184,999.60	800.40	100.0
210401	Бичиг хэрэг	421,800.00	456,000.00	-34,200.00	108.1
210402	Тээвэр, шатахуун	3,701,700.00	3,684,490.00	17,210.00	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,300.00	974,039.60	26,260.40	97.4
210404	Ном, хэвлэл	213,800.00	100,000.00	113,800.00	46.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	971,600.00	1,077,900.00	-106,300.00	110.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	876,600.00	892,570.00	-15,970.00	101.8
2105	Нормативт зардал	615,600.00	615,600.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	615,600.00	615,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,500.00	165,130.00	5,370.00	96.9
210604	Урсгал засвар	170,500.00	165,130.00	5,370.00	96.9
2107	Томилолт, зочны зардал	63,600.00	54,000.00	9,600.00	84.9
210702	Дотоод албан томилолт	63,600.00	54,000.00	9,600.00	84.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,208,500.00	12,202,311.00	6,189.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,208,500.00	12,202,311.00	6,189.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,797,600.00	13,760,200.00	37,400.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	249,000.00	220,000.00	29,000.00	88.4
210902	Хичээл	13,548,600.00	13,540,200.00	8,400.00	99.9

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Үйлдвэрлэлийн дадлага хийх				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,829,228,200.00	2,761,907,693.40	67,320,506.60	97.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,829,228,200.00	2,761,907,693.40	67,320,506.60	97.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,424,658,500.00	1,397,860,603.40	26,797,896.60	98.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,404,241,700.00	1,363,719,090.00	40,522,610.00	97.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,223,178,600.00	3,153,997,537.20	69,181,062.80	97.9
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,223,178,600.00	3,153,997,537.20	69,181,062.80	97.9
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,223,178,600.00	3,153,997,537.20	69,181,062.80	97.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	0.00	0.0
620001	Удирдах ажилтан			0.00	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан			0.00	0.0
620003	Үйлчлэх ажилтан			0.00	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,874,961.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,874,961.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,331,261.82
2104	Хангамж, бараа материалын зардал	41,838,841.82
210401	Бичиг хэрэг	16,003,641.82
210402	Тээвэр, шатахуун	86,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,748,800.00
2105	Нормативт зардал	3,018,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,018,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,901,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,901,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,573,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,573,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,043,700.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,043,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,874,961.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	364,874,961.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,086,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,018,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,270,561.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,500,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихэр мөрөн аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Боловсролын газар нь боловсролын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх, тайлагнах үйл ажиллагаа явуулдаг Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,484.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 69.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 55.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97.0 сая төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

/Сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	00	3.0	3,0
Урьдчилгаа	00	00	
Бараа материал	2.7	1.9	(0,8)
Үндсэн хөрөнгө	1,008.0	1,102.8	94.8
Нийт хөрөнгө	1,010.7	1,107.7	97.0
Өр төлбөр	4.5	00	(4,5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,006.2	1,107.7	101.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,010.7	1,107.7	97.0

Авлага дансанд 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Байгаль орчны мэдээлэл сургалтын төвөөс санхүүжигдсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төслийн мөнгө зарцуулагдаагүй бөгөөд Төрийн санд төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.9 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буюу 29.6 хувиар буурсан байна. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан бараа материал 23.3 сая төгрөг, БШУЯам, Жайка төслөөс аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад автомакс, ариутгалын спирт 9.3 сая төгрөг, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд

сургуулиудад бага ангийн хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн 74.5 сая төгрөг, БШУЯ-аас 131.2 сая төгрөгийн нөхөн хангалтын сурах бичиг нийт 215.0 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бараа материалыг сургууль цэцэрлэгүүдэд олгосон байна. Үйл ажиллагаанд 26.5 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,102.8 сая төгрөг болж 94.8 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан машин тоног төхөөрөмж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19.9 сая төгрөгийн компьютер, өнгөт принтер, багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж, БШУЯ-аас мэдээлэл технологийн техник хэрэгсэл үнэ төлбөргүй, БШУЯ-аас 48.0 сая төгрөгийн Тоёота Ланд круйзер-200 автомашин баланс хооронд шилжүүлэн хүлээн авсан байна.

Боловсрол мэдээллийн технологийн төвийн санхүүжилтээр 19.0 сая төгрөгийн контент боловсруулах лабораторийн тоног төхөөрөмж, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хөрөнгөөр 4.7 сая төгрөгийн ухаалаг самбар, проектор, камер худалдан авсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 116 ширхэг 71.9 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 47.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,107.7 сая төгрөг болж 101.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 464.6 сая төгрөгөөр буюу 13.4 өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь нэмэлт санхүүжилтийн орлого данс байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг 3,825.4 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 340.6 сая төгрөгөөр өсч, нийт үр дүн 124.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын төсвийг 519.8 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн бөгөөд БШУЯ-аас 358.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Сангийн яамнаас 2021 оны 04 сарын 26-нд тодотгол хийж, тус байгууллагын төсвийг 6.9 сая төгрөгөөр бууруулснаар төсвийн зарлага 351.2 сая төгрөг болжээ. 2021 оны 07 дугаар сарын 21-нд нэмэлт тодотгол хийж цалин шимтгэлийн зардалд 386.3 сая төгрөг болж 35.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2021 оны 12 сард тодотгол хийж 7.7 сая төгрөгөөр нэмэгдэж 394.0 сая төгрөг болсон байна.

БШУЯ-аас сургууль, цэцэрлэгүүдийн ажилчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид нийт 2,829.3 сая төгрөг Боловсролын газрын 100170015001 тоот дансаар орж гүйцэтгэлээр 2,761.9 сая төгрөг олгогдож 67.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Боловсролын бодлого удирдлагын /71808/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 394.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлийг 384.5 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 394.0 сая төгрөгтэй харьцуулахад 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 1.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 22.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах 364.9 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна. Үүнд:

- Байгаль орчин мэдээлэл сургалтын төвөөс “Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төслөөс 6.0 сая төгрөг
- БШУЯ-аас “Хүүхэд харах үйлчилгээ”-ний санхүүжилт 13.5 сая төгрөг
- БШУЯ-аас сургууль, цэцэрлэгийн ариутгалын зардалд 25.7 сая төгрөг
- БШУЯ-аас “Багш шавийн барилдлага” үзэсгэлэнгийн зардалд 4.6 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас 2021 оны ЭЕШ-д амжилттай оролцсон сурагч, багш нарын шагналын зардалд 15.0 сая төгрөг
- ЭЕШ өгөх сурагчдыг витаминжуулах зардалд 3.0 сая төгрөг
- Боловсролын чанарын шинэчлэл төслөөс “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр-5”-ийн зардал 258.0 сая төгрөг
- Боловсролын мэдээллийн технологийн төвөөс Контент боловсруулах лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах зардалд 19.0 сая төгрөг
- Боловсролын үнэлгээний төвөөс “Оношлох үнэлгээний шалгалт”-ын бичиг хэргийн зардалд 16.0 сая төгрөг
- Тогтвортой ноос ноолуурын эвслээс “Шинэ зууны малчин” хөтөлбөрийн 1-р улирлын урамшуулалд 3.5 сая төгрөг
- Боловсролын үнэлгээний төвөөс “Оношлох үнэлгээний шалгалт”-ын ажилтны шатахууны зардалд 0.6 сая төгрөг

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтны удирдамж шийдвэрийн дагуу зохих зардалд зарцуулах эрхийг нээлгэж зарцуулсан байна. Нийт зарлага 361.8 сая төгрөг бөгөөд зарцуулагдаагүй үлдсэн 3.0 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын

хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Боловсролын газар нь 2021 онд нийт 6,653.9 сая төгрөгийн 128 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6,653.9 сая төгрөгийн 128 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж, 1 төлбөрийн актын хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн боловсролын газарт 2021 оны санхүүгийн тайлан тасалбар болгосон ба тайланг батламжилсан өдрийн хооронд тайланд нөлөө үзүүлж болохуйц үйл явдал болоогүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо: 0/24

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

